

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/141/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Чингис хот

2022 он

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Туяа  
Утас: 99028942 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Contents

Contents.....	1
<b>1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....</b>	<b>3</b>
<b>2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....</b>	<b>4</b>
<b>2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....</b>	<b>4</b>
<b>2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....</b>	<b>5</b>
<b>2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....</b>	<b>7</b>
<b>2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....</b>	<b>8</b>
<b>2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....</b>	<b>11</b>
<b>2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....</b>	<b>13</b>
<b>3. Аудитын тайлан.....</b>	<b>14</b>
3.1 Ерөнхий зүйл .....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
<b>4. Аудитын илрүүлэлт .....</b>	<b>17</b>
4.2 Албан шаардлага.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
<b>6. Аудитын тайлангийн хавсралт.....</b>	<b>18</b>
<b>6.1. Албан шаардлага 2021.03.09 №</b>	<b>ХЭА-2022/141/НА-СТА-ТШЗ</b>
Албан шаардлага 2021.03.09 №	ХЭА-2022/141/НА-СТА-ТШЗ
Албан шаардлага 2021.03.09 №	ХЭА-2022/141/НА-СТА-ТШЗ
Төлбөрийн акт 2021.03.09 №	ХЭА-2022/141/НА-СТА-ТШЗ

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2022.03.09 № 190  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотсод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>159,143,737.00</u></b>	<b><u>178,476,739.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	10,717,763.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	10,717,763.00
3351	Байгууллагаас авах авлага	-	10,717,763.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	180,000.00	180,000.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	180,000.00	180,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	180,000.00	180,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	158,963,737.00	167,578,976.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	1,306,460.00
35130	Эм боох материал	-	1,306,460.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	152,442,007.00	159,750,786.00
35410	Бичиг хэргийн материал	6,221,316.00	4,811,116.00
35420	Аж ахуйн материал	142,405,286.00	142,394,570.00
35440	Тулш, шатах тослох материал	3,706,145.00	6,005,000.00
35450	Барилгын засварын материал	-	5,940,100.00
35460	Хүнсний материал	109,260.00	-
35470	Бусад хангамжийн материал	-	600,000.00
35600	Мал амьтад	6,521,730.00	6,521,730.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,850,385,539.17</u></b>	<b><u>4,234,938,871.65</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,850,385,539.17	4,234,938,871.65
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,739,220,121.99	3,064,410,213.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,734,712,201.69	3,094,968,250.69
39202	Хуримтлагдсан элэгдэл	(120,901,446.60)	(196,701,257.83)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	122,399,903.00	182,399,903.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(82,622,125.40)	(95,849,902.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	148,462,905.20	161,052,805.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(109,801,475.31)	(120,479,790.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	115,149,325.92	115,149,325.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	(69,735,342.90)	(77,072,103.27)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,011,600.00	9,011,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,455,423.61)	(8,068,616.80)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,111,165,417.18	1,170,528,658.16
39301	Програм хангамж	1,810,000.00	1,810,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,769,582.82)	(1,809,999.84)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,112,575,000.00	1,171,978,658.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,450,000.00)	(1,450,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,009,529,276.17</u></b>	<b><u>4,413,415,610.65</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>4,009,529,276.17</u></b>	<b><u>4,413,415,610.65</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,009,529,276.17	4,413,415,610.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,234,447,071.90	1,234,447,071.90
51101	Өмч: - төрийн	1,234,447,071.90	1,234,447,071.90
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,786,433,532.71	2,190,319,867.19
51210	Өмнөх үеийн үр дүн	1,786,433,532.71	1,786,433,532.71
51220	Тайлант үеийн үр дүн	-	403,886,334.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	988,648,671.56	988,648,671.56
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>4,009,529,276.17</u></b>	<b><u>4,413,415,610.65</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,326,035,127.20</b>	<b>1,572,037,446.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>211,589,426.20</b>	<b>299,412,947.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	211,589,426.20	299,412,947.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	211,589,426.20	299,412,947.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,583,500.00	2,029,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	206,005,926.20	297,383,947.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,114,445,701.00</b>	<b>1,272,624,499.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	56,813,401.00	133,600,499.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	1,230,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,890,549.00	116,068,999.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,922,852.00	16,301,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,057,632,300.00	1,139,024,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,057,632,300.00	1,139,024,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,190,227,218.50</b>	<b>1,168,151,111.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,146,082,033.50</b>	<b>1,136,758,496.52</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,026,256,363.24	1,043,238,273.17
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	450,079,281.00	469,750,290.50
210101	Үндсэн цалин	310,916,735.81	180,564,888.26
210102	Нэмэгдэл	67,418,490.24	72,681,922.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,516,502.23	29,958,897.17
210105	Гэрээт ажлын хөлс	39,227,552.72	186,544,583.07
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	58,501,762.01	62,777,130.21
210201	Тэтгэврийн даатгал	40,165,096.67	43,963,522.62
210202	Тэтгэмжийн даатгал	4,606,631.45	4,800,568.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,739,623.41	3,786,814.94
210204	Ажилгүйдлийн даатгал	926,636.40	929,529.45
210205	Эрүүл мэндийн даатгал	9,063,774.08	9,296,694.56
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	122,647,749.00	121,854,037.38
210301	Гэрэл, цахилгаан	11,870,722.60	11,651,058.58
210302	Түлш, халаалт	102,040,282.40	100,166,194.80
210303	Цэвэр, бохир ус	6,577,744.00	7,466,784.00
210304	Байрны түрээс	2,159,000.00	2,570,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	37,384,389.80	37,060,827.93
210401	Бичиг хэрэг	5,418,430.00	6,459,730.00
210402	Тээвэр, шагахуун	23,014,063.30	17,268,815.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,355,473.50	9,672,876.93
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	420,000.00

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	596,423.00	2,726,906.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	512,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,089,320.00	2,656,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	2,055,000.00
210502	Хоол, хүнс	-	387,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,089,320.00	214,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	29,626,608.00	18,091,726.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	54,780.00
210604	Урсгал засвар	29,626,608.00	18,036,946.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,600,500.00	4,487,000.00
210702	Дотоод албан томилолт	8,600,500.00	4,487,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	92,639,071.00	89,788,813.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,375,274.00	85,356,749.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,868,133.00	1,900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	249,364.00	220,564.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	98,400.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	500,000.00
210807	Газрын төлбөр	327,900.00	294,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	225,687,682.43	236,771,848.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	125,964,162.23	128,060,073.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	945,400.00	1,015,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,778,120.20	107,696,274.52
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	119,825,670.26	93,520,223.35
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	59,221,871.45	52,438,352.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,045,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,176,271.45	52,438,352.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	41,081,871.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	41,081,871.35
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	60,603,798.81	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	60,603,798.81	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>44,145,185.00</b>	<b>31,392,615.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	44,145,185.00	31,392,615.00
221001	Их засвар	-	29,566,631.00
223001	Бусад хөрөнгө	44,145,185.00	1,825,984.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>135,807,908.70</b>	<b>403,886,334.48</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>135,807,908.70</b>	<b>403,886,334.48</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,234,447,071.90	988,648,671.56	1,650,933,646.01	3,874,029,389.47
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(308,022.00)	(308,022.00)
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,234,447,071.90</b>	<b>988,648,671.56</b>	<b>1,650,625,624.01</b>	<b>3,873,721,367.47</b>
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	135,807,908.70	135,807,908.70
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,234,447,071.90</b>	<b>988,648,671.56</b>	<b>1,786,433,532.71</b>	<b>4,009,529,276.17</b>
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,234,447,071.90</b>	<b>988,648,671.56</b>	<b>1,786,433,532.71</b>	<b>4,009,529,276.17</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,234,447,071.90</b>	<b>988,648,671.56</b>	<b>1,786,433,532.71</b>	<b>4,009,529,276.17</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	403,886,334.48	403,886,334.48
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,234,447,071.90</b>	<b>988,648,671.56</b>	<b>2,190,319,867.19</b>	<b>4,413,415,610.65</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,120,029,201.00</b>	<b>1,274,653,499.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,583,500.00</b>	<b>2,029,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,583,500.00	2,029,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,583,500.00	2,029,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,583,500.00	2,029,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>1,114,445,701.00</b>	<b>1,272,624,499.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	56,813,401.00	133,600,499.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	1,230,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,890,549.00	116,068,999.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,922,852.00	16,301,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,057,632,300.00	1,139,024,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,057,632,300.00	1,139,024,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,053,619,511.00</b>	<b>1,049,146,784.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,053,619,511.00</b>	<b>1,049,146,784.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>932,489,950.74</b>	<b>946,882,147.65</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	450,079,281.00	469,750,290.50
210101	Үндсэн цалин	310,916,735.81	180,607,355.26
210102	Нэмэгдэл	67,418,490.24	72,639,455.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,516,502.23	29,958,897.17
210105	Гэрээт ажлын хөлс	39,227,552.72	186,544,583.07
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	58,501,762.01	62,777,130.21
210201	Тэтгэврийн даатгал	40,165,096.67	43,963,522.62
210202	Тэтгэмжийн даатгал	4,606,631.45	4,800,568.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,739,623.41	3,786,814.94
210204	Ажилгүйдлийн даатгал	926,636.40	929,529.45
210205	Эрүүл мэндийн даатгал	9,063,774.08	9,296,694.56
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	122,647,749.00	126,854,037.38
210301	Гэрэл, цахилгаан	11,870,722.60	11,651,058.58
210302	Түлш, халаалт	102,040,282.40	105,166,194.80
210303	Цэвэр, бохир ус	6,577,744.00	7,466,784.00
210304	Байрны түрээс	2,159,000.00	2,570,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	39,433,579.50	30,660,084.93
210401	Бичиг хэрэг	7,228,930.00	5,201,430.00

**Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210402	Тээвэр, шатахуун	21,949,500.00	13,750,670.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,069,473.50	9,088,656.93
210404	Ном, хэвлэл	319,493.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	420,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	866,183.00	2,199,328.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>738,360.00</b>	<b>588,750.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	738,360.00	588,750.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>32,028,176.00</b>	<b>24,265,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	11,990,000.00
210604	Урсгал засвар	32,028,176.00	12,275,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,600,500.00</b>	<b>4,487,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,600,500.00	4,487,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>94,793,371.00</b>	<b>94,741,563.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,529,574.00	78,309,499.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,868,133.00	1,900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	249,364.00	220,564.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	98,400.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	12,500,000.00
210807	Газрын төлбөр	327,900.00	294,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>125,667,172.23</b>	<b>132,757,391.63</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	124,699,772.23	131,650,891.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	967,400.00	1,106,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>121,129,560.26</b>	<b>102,264,636.35</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>60,525,761.45</b>	<b>50,465,002.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,045,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,480,161.45	50,465,002.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>57,908,271.31</b>	<b>41,081,871.35</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,908,271.31	41,081,871.35
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,695,527.50</b>	<b>10,717,763.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,695,527.50	10,717,763.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>66,409,690.00</b>	<b>225,506,715.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>66,409,690.00</b>	<b>225,506,715.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>66,409,690.00</b>	<b>225,506,715.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>66,409,690.00</b>	<b>225,506,715.00</b>
221001	Их засвар	-	50,581,097.00

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

222001	Тоног төхөөрөмж	22,264,505.00	-
223001	Бусад хөрөнгө	44,145,185.00	174,925,618.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(66,409,690.00)</b>	<b>(225,506,715.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,141,994,000.00	1,099,971,128.65	42,022,871.35
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	987,663,800.00	953,959,750.65	33,704,049.35
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	967,417,800.00	933,714,748.65	33,703,051.35
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	477,014,100.00	469,750,290.50	7,263,809.50
210101	Үндсэн цалин	301,929,000.00	180,607,355.26	121,321,644.74
210102	Нэмэгдэл	84,428,800.00	72,639,455.00	11,789,345.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,380,000.00	29,958,897.17	4,421,102.83
210105	Гэрээт ажлын хөлс	56,276,300.00	186,544,583.07	(130,268,283.07)
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	67,626,700.00	62,777,130.21	4,849,569.79
210201	Тэтгэврийн даатгал	47,924,800.00	43,963,522.62	3,961,277.38
210202	Тэтгэмжийн даатгал	4,887,500.00	4,800,568.64	86,931.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,031,100.00	3,786,814.94	244,285.06
210204	Ажилгүйдлийн даатгал	1,007,800.00	929,529.45	78,270.55
210205	Эрүүл мэндийн даатгал	9,775,500.00	9,296,694.56	478,805.44
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	145,649,700.00	126,854,037.38	18,795,662.62
210301	Гэрэл, цахилгаан	12,686,000.00	11,651,058.58	1,034,941.42
210302	Түлш, халаалт	122,893,700.00	105,166,194.80	17,727,505.20
210303	Цэвэр, бохир ус	7,500,000.00	7,466,784.00	33,216.00
210304	Байрны түрээс	2,570,000.00	2,570,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28,060,800.00	27,784,084.93	276,715.07
210401	Бичиг хэрэг	4,851,500.00	4,851,430.00	70.00
210402	Тээвэр, шатахуун	11,735,500.00	11,734,670.00	830.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,579,100.00	8,578,656.93	443.07
210404	Ном, хэвлэл	274,700.00	-	274,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	420,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,200,000.00	2,199,328.00	672.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	590,000.00	588,750.00	1,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	590,000.00	588,750.00	1,250.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,193,900.00	23,965,900.00	228,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.00	11,990,000.00	10,000.00
210604	Урсгал засвар	12,193,900.00	11,975,900.00	218,000.00

**Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,350,100.00	4,487,000.00	863,100.00
210702	Дотоод албан томилолт	5,350,100.00	4,487,000.00	863,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	92,506,500.00	90,895,664.00	1,610,836.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,000,000.00	74,463,600.00	1,536,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	1,440,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,900,000.00	1,900,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	252,000.00	220,564.00	31,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	77,000.00	43,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,500,000.00	12,500,000.00	-
210807	Газрын төлбөр	294,500.00	294,500.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	126,426,000.00	126,611,891.63	(185,891.63)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	125,619,500.00	125,805,391.63	(185,891.63)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	806,500.00	806,500.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20,246,000.00	20,245,002.00	998.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	20,246,000.00	20,245,002.00	998.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,246,000.00	20,245,002.00	998.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>154,330,200.00</b>	<b>146,011,378.00</b>	<b>8,318,822.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	154,330,200.00	146,011,378.00	8,318,822.00
223001	Бусад хөрөнгө	154,330,200.00	146,011,378.00	8,318,822.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,141,994,000.00</b>	<b>1,099,971,128.65</b>	<b>42,022,871.35</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,139,024,000.00</b>	<b>1,097,942,128.65</b>	<b>41,081,871.35</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,139,024,000.00	1,097,942,128.65	41,081,871.35
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2,970,000.00</b>	<b>2,029,000.00</b>	<b>941,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,970,000.00	2,029,000.00	941,000.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>133,600,499.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>54,105,162.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>13,167,399.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,876,000.00
210401	Бичиг хэрэг	350,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,016,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	510,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	300,000.00
210604	Урсгал засвар	300,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,845,899.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,845,899.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,145,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,845,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,220,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,220,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,220,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,717,763.00</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	10,717,763.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>79,495,337.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	79,495,337.00
221001	Их засвар	50,581,097.00
223001	Бусад хөрөнгө	28,914,240.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>133,600,499.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>133,600,499.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,230,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,068,999.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,301,500.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Туяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 2/27 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүргийг “харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах...” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,190.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 11.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж үзээд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,168.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 11.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг материаллаг байдлын 75 хувиар буюу 8.8 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 4,413.4 сая төгрөг болж, өмнөх оноос 403.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт / сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	10.7	10.7
Урьдчилгаа	0.2	0.2	-
Бараа материал	158.9	167.6	8.7
Үндсэн хөрөнгө	3,850.4	4,234.9	384.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,009.5</b>	<b>4,413.4</b>	<b>403.9</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оруулсан капитал	1,234.4	1,234.4	-
Хуримтлагдсан үр дүн	1,786.4	2,190.3	403.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	988.7	988.7	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,009.5</b>	<b>4,413.4</b>	<b>403.9</b>

Авлага дансны үлдэгдэл 10.7 сая төгрөг болж нэмэгдсэн нь нэмэлт дансны үлдэгдлийг төвлөрүүлж авлагаар тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 167.6 сая төгрөг болж 8.7 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,234.9 сая төгрөг болж 384.5 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 286.1 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн, 206.1 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 2,190.3 сая болж 403.9 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 246.0 сая төгрөгөөр буюу 18.5 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 91.4 сая төгрөгөөр, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 86.2 сая төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 81.4 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 22.1 сая төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс эд хогшил, урсгал засварын зардал 11.5 сая төгрөгөөр, албан томилолтын зардал 4.0 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 4.0 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэг 26.3 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 971.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 167.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,139.0 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,142.0 сая төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 1,139.0 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 3.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,139.0 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 2.3 сая, нийт 1,142.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,100.0 сая төгрөгийг зарцуулж 41.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1.2 сая, дээд шатны төсөв захирагчаас 116.1 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 16.3 сая, нийт 133.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийт мэдээлбэл зохих 2,239.4 сая төгрөгийн 236 мэдээллээс 1,650.6 сая мянган төгрөгийн 219 мэдээллийг мэдээлж, 588.9 сая төгрөгийн 29 мэдээллийг мэдээлээгүй байна. Үүнд: Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 308.6 сая төгрөгийн 10 худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 117.0 сая төгрөгийн 7 гүйлгээ, зарлагын 163.3 сая төгрөгийн 12 гүйлгээг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгснөөс шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлэх зөвлөмжөөс бусад зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актыг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдлийг тулгахаар шийдвэрлэв.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 618.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 617.8 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 0.6 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

#### **4.2 Төлбөрийн акт**

1. Багийн ахлагч нарт олгох урамшууллыг байгуулсан гэрээнээс 0.6 сая төгрөгөөр илүү олгосныг төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

#### 4.3 Албан шаардлага

Аудитаар залруулагдаагүй 617.8 сая төгрөгийн зөрчлийг дахин давтахгүй байх 3 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Батлагдсан төсвийн хүрээнд тэвчиж болох 26.7 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.
2. Шилэн дансны нийт мэдээлбэл зохих 2,239.4 сая төгрөгийн 236 мэдээллээс 1,650.6 сая мянган төгрөгийн 219 мэдээллийг мэдээлж, 588.9 сая төгрөгийн 29 мэдээллийг мэдээлээгүй байна. Үүнд: Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 308.6 сая төгрөгийн 10 худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 117.0 сая төгрөгийн 7 гүйлгээ, зарлагын 163.3 сая төгрөгийн 12 гүйлгээг мэдээлээгүй байна.
3. Орон сууцанд амьдардаг ажилтнуудад 2.2 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгож, батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
/сая төгрөгөөр/											
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар	3	29.5			1	0.6	2	28.9		
<b>Дүн</b>		<b>3</b>	<b>29.5</b>			<b>1</b>	<b>0.6</b>	<b>2</b>	<b>28.9</b>		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар	1	588.9					1	588.9		
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>588.9</b>					<b>1</b>	<b>588.9</b>		
<b>Нийт дүн</b>		<b>4</b>	<b>618.4</b>			<b>1</b>	<b>0.6</b>	<b>3</b>	<b>617.8</b>		

#### 6. Аудитын тайлангийн хавсралт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 123/А2370НМ7  
ХТЭА 2022/141/НА-СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн хэмжээнд тэвчиж болох 26.7 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Наранбат, нягтлан бодогч Д.Баярмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Н.ТУЯА

Д.ОЮУНТУЯА

2317144297  
СЮА0045 9074082



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 124/А2370447  
ХТА 2022/И1/НА ЕТА ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон сууцанд амьдардаг ажилтнуудад 2.2 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгож, батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Наранбат, нягтлан бодогч Д.Баярмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Н.ТУЯА

Д.ОЮУНТУЯА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 125/А 2370447  
ХТХ - 2022/141/НА-ГА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нийт мэдээлбэл зохих 2,239.4 сая төгрөгийн 236 мэдээллээс 1,650.6 сая мянган төгрөгийн 219 мэдээллийг мэдээлж, 588.9 сая төгрөгийн 29 мэдээллийг мэдээлээгүй байна. Үүнд: Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 308.6 сая төгрөгийн 10 худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 117.0 сая төгрөгийн 7 гүйлгээ, зарлагын 163.3 сая төгрөгийн 12 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулдаггүй зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Наранбат, нягтлан бодогч Д.Баярмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Н.ТУЯА

Д.ОЮУНТУЯА

2317144297

СЮА0046 9074082



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 16/АДЗТ0447  
ХТА 2022/141/НА-СТА-ТЦЗ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймаг Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Багийн ахлагч нарт олгох урамшууллыг байгуулсан гэрээнээс 0.6 сая төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү олгосон 0.6 сая төгрөгийг Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэрлэн сумын ЗДТГ-ын дарга Л.Наранбат, нягтлан бодогч Д.Баярмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Н.ТУЯА

Д.ОЮУНТУЯА

2317144297  
СЮА0046 9074082